



БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН САЙДЫН ТУШААЛ

2024 оны 9 дүгээр сарын 12-ны өдөр

Дугаар А/698

Улаанбаатар хот

ЖУРАМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэх, худалдах журам"-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Энэхүү журмыг Захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг Хүрээлэн буй орчны бодлого зохицуулалтын газар /Г.Энхмөнх/, Салбарын хяналтын газар /Б.Мөнхтогтох/-т тус тус үүрэг болгосугай.

САЙД С.ОДОНТУЯА

ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИС ЭКСПОРТЛОХ, ИМПОРТЛОХ, ХИЛ ДАМЖУУЛАН ТЭЭВЭРЛЭХ БОЛОН ҮЙЛДВЭРЛЭХ, ХУДАЛДАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалт, 8, 9, 11, 15, 18 дугаар зүйлд заасан химийн хорт болон аюултай бодисыг экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, худалдахтай холбогдсон үйл ажиллагааг зохицуулахад энэхүү журмыг мөрдөнө.

1.2.Химийн хорт болон аюултай бодисыг экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, худалдах зөвшөөрөлтэй хүн, хуулийн этгээдэд тавигдах шаардлага болон экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, худалдах үед химийн хорт болон аюултай бодисоос хамгаалах эрх зүйн хэм хэмжээг тогтоон зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.3.Химийн бодис гэдэгт химийн хорт болон аюултай бодис болон химийн хорт болон аюултай бодисын босго хязгаараас их хортой, аюултай бодисыг агуулсан бүтээгдэхүүнийг хамруулж ойлгоно.

1.4.Босго хязгаарыг тогтоохдоо химийн бодисын ангилал, хаягжуулалтын нэгдсэн ситемийн болон Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2-т заасан химийн хорт болон аюултай бодисын ангиллыг ашиглах аргачлалд заасан босго хэмжээг баримтална.

1.5.Озон задалдаг бодисыг импортлох, худалдах, ашиглахтай холбогдсон үйл ажиллагааг Засгийн газрын “Озон задалдаг бодис болон бусад орлуулах бодис, тэдгээрийг агуулсан тоног төхөөрөмжийг импортлох, худалдах, ашиглах тусгай зөвшөөрөл олгох журам”-аар зохицуулна.

1.6.Газрын тосны бүтээгдэхүүнийг импортлох, худалдах, ашиглахтай холбогдсон үйл ажиллагааг Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийг дагалдаж гарах журмаар зохицуулна.

Хоёр.Химийн хорт болон аюултай бодисыг экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, худалдах үйл ажиллагаанд тавигдах нийтлэг шаардлага

2.1.Ерөнхий зүйл

2.1.1.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хүн, хуулийн этгээдийн албан ёсны хүсэлт, хуульд заасан холбогдох бичиг баримтыг үндэслэн, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.14 дэх заалт, Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан зөвшөөрлийг олгоно;

2.1.2.Химийн бодисыг Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэлийн байгаль орчны хяналтын улсын байцаагчийн олгосон дүгнэлттэй, “Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах” стандартын шаардлага хангасан, зориулалтын агуулахад хадгална;

2.1.3.Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэгт заасан химийн бодис улсын хилээр нэвтрүүлэх боомт, гүний гаалийн хяналтын бүс нь ачиж буулгах зориулалтын талбай, өргөж буулгах авто техник, “Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах” стандартын шаардлага хангасан агуулахтай байх ба химийн бодисыг тусдаа гарцаар саад дараалалгүйгээр түргэн шуурхай нэвтрүүлнэ;

2.1.4.Химийн бодисын тусгай зөвшөөрөл бүхий хүн, хуулийн этгээд нь экспортолсон, импортолсон болон хил дамжуулан тээвэрлэсэн, үйлдвэрлэсэн, худалдсан химийн бодисын мэдээллийг тухай бүр нь байгаль орчны мэдээллийн сан дахь химийн хорт болон аюултай бодисын бүртгэл, мэдээллийн системд бүртгүүлнэ;

2.1.5.Химийн бодисын зөвшөөрөл бүхий хүн, хуулийн этгээд нь химийн хорт болон аюултай бодис хадгалах агуулахаа холбогдох журам, стандартын шаардлага хангаж байгаа эсэхэд аймаг, нийслэлийн байгаль орчны байцаагчаар дүгнэлт гаргуулсан байна;

2.1.6.Химийн бодисын тусгай зөвшөөрлийг хүн, хуулийн этгээдийн хэрэгжүүлж байгаа төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд тусгагдсан цар хүрээ, химийн бодисын нэр төрөл, ашиглах, хадгалах тоо хэмжээ, цаг хугацааг харгалзан олгоно;

2.1.7.Химийн бодисыг анхааруулах тэмдэг бүхий зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэх бөгөөд тээвэрлэх, ачих, буулгах үеийн аюулгүй ажиллагааг химийн бодис импортлох, экспортлох, хил дамжуулан тээвэрлэх, худалдах үйл ажиллагаа эрхлэгч хариуцна;

2.1.8.Химийн бодисыг экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, худалдах үйл ажиллагаа эрхлэгч нь тээвэрлэгч байгууллагатай гэрээ байгуулахдаа тухайн бодисын монгол хэл дээрх хор, аюулгүй байдлын лавлах мэдээлэл, аюулгүй ажиллагааны зааварчилгаа, болзошгүй ослын үед ажиллах төлөвлөгөө, тээвэрлэх маршрут зэргийг танилцуулж гарын үсэг зуруулна;

2.1.9.Химийн бодисын тусгай зөвшөөрөл хүн, хуулийн этгээд нь химийн хорт болон аюултай бодисын талаар гарсан олон улсын гэрээ, хэлэлцээрийг биелүүлэх үүрэгтэй бөгөөд тээвэрлэлт, ачилт, буулгалтын үед гарч болох осол, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, осол, алдагдал гарсан тохиолдолд өөрийн хөрөнгөөр хор, аюулыг бууруулах арга хэмжээ авах нөхцөлийг бүрдүүлсэн байна;

2.1.10.Химийн бодисын тусгай зөвшөөрөл бүхий хүн, хуулийн этгээд нь химийн бодис тээвэрлэх маршрутыг нэг аймгийн нутаг дэвсгэр дотор бол тухайн аймгийн онцгой байдлын асуудал хариуцсан байгууллагаар, хоёр буюу түүнээс дээш аймгийн нутаг дэвсгэрээр дамжин тээвэрлэхэд онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаар хянуулан, өөрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтанаараа батлуулж, тээвэрлэлт эхлэхийн өмнө хугацааг мэдэгдэнэ;

2.1.11.Химийн бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэх, худалдах тусгай зөвшөөрөл бүхий хүн, хуулийн этгээд нь техникийн бүрэн бүтэн байдал хангасан тээврийн хэрэгслээр химийн бодисыг өдрийн цагаар тээвэрлэнэ;

2.1.12.Химийн бодисын тусгай зөвшөөрөл хүн, хуулийн этгээд химийн бодис бүрийн нийлүүлэлт, зарцуулалтын хөдөлгөөний тухайн жилийн тайланг гаргаж, дараа жилийн 1 дүгээр сард багтаан байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ;

2.1.13.Химийн бодисын тусгай зөвшөөрөл бүхий хүн, хуулийн этгээдийн зөвшөөрлийн хугацаа нь дуусаагүй боловч химийн бодисын зөвшөөрсөн хэмжээ дууссан бол Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас дахин тусгай зөвшөөрөл олгож болно;

2.1.14.Монгол Улсын хилээр англи, орос, монгол хэл дээр бичигдсэн хаяг шошготой химийн бодисыг нэвтрүүлнэ. Хэрэв бусад улсын хэлээр бичигдсэн бол давхар англи хэлээр бичигдсэн хаяг шошготой байж болно.

2.2.Доорх төрлийн химийн бодис, химийн бодис агуулсан бүтээгдэхүүнийг импортлоход энэхүү журам хамаарахгүй. Үүнд:

2.2.1.Судалгаа, шинжилгээний зориулалтаар ашиглах 1 литр эсвэл 1 кг болон түүнээс бага савлагаатай, нийт хэмжээ 25 кг-аас ихгүй, “Монгол Улсад ашиглахыг хориглосон химийн хорт болон аюултай бодисын жагсаалт” болон “Монгол Улсад ашиглахыг хязгаарласан химийн хорт болон аюултай бодисын жагсаалт”-д ороогүй бодис, урвалж, тэжээлт орчин, стандарт бодис;

2.2.2.Барилгын материалын норматив, стандарт шаардлага хангасан гэрчилгээтэй, үйлдвэрлэгчийн савлагаатай барилгын будаг, лак, цавуу, эмульс, чигжээс, шаваас;

2.2.3.Барилга байгууламж, ахуйн хэрэглээнд шууд хэрэглэх зориулалттай, стандартын шаардлага хангасан, үйлдвэрлэгчийн савлагаатай, хаяг, шошго, лац бүхий галын хор;

2.2.4.Барилгын бүтээц, шугам хоолой, дулаалгын материал үйлдвэрлэх зориулалттай, удаан задардаг органик бохирдуулагч агуулаагүй полимер түүхий эд болон бетоны чанар сайжруулах, бэхжүүлэх зориулалттай нэмэлтээр ашиглах бэлдмэл;

2.2.5.Шахсан хий бүхий ахуйн зориулалттай асаагуур;

2.2.6.Жижиглэн борлуулах зориулалтаар савлагдсан ахуйн зориулалттай 2000 мл, эсхүл 2000 граммаас бага хэмжээтэй уусгагч, хэвлэлийн хор, будаг, фото зургийн хор болон үйлдвэрлэгчийн савлагаа, чанарын гэрчилгээтэй, стандартын шаардлага хангасан хаяг шошготой хэвлэлийн үйлдвэрлэлд шууд хэрэглэх зориулалттай цавуу, будаг, лак;

2.2.7.Шохойн чулуу, боловсруулсан шохой, гипс, каолин, бентонит, цеолит, графит, цахиурын исэл буюу кварц, антрацит, идэвхжүүлсэн нүүрс, ус шүүх, цэвэрлэх зориулалттай анионит, катионитууд, гангийн үйлдвэрлэлд ашиглах чанар сайжруулагч төмрийн хайлшууд;

2.2.8.Үйлдвэрлэгчийн савлагаа, чанарын гэрчилгээтэй, стандартын шаардлага хангасан хаяг шошготой, шууд хэрэглэх зориулалттай химийн бодис агуулсан ахуйн болон гоо сайхны бүтээгдэхүүнүүд;

2.2.9.Бүх төрлийн савлагаатай ахуйн зориулалттай угаалга, цэвэрлэгээний бүтээгдэхүүнүүд;

2.2.10.Үйлдвэрлэлийн зориулалттай ашиглах өнгө, үнэр оруулагч, нунтаг экстракт, желатин, декстрин, цардуул, ундааны нүүрсхүчлийн хий, эрдсийн гаралтай чийг татагч зэрэг бүтээгдэхүүнүүд;

2.2.11.Үйлдвэрлэгчийн савлагаатай, стандартын шаардлага хангасан хаяг, шошго, бүхий ахуйн зориулалтаар ашиглах 70 болон түүнээс бага хувийн этилийн спирт, ариутган халдваргүйжүүлэх зориулалттай бусад химийн бодис бэлдмэл агуулсан гар халдваргүйжүүлэгч бодис, бүтээгдэхүүн;

2.2.12.Үйлдвэрлэгчээс тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг шалгах, тохируулах зориулалттай, тухайн тоног төхөөрөмжтэй хамт импортлогдож байгаа нийт хэмжээ нь 25 кг эсвэл 25 литрээс ихгүй, “Монгол Улсад ашиглахыг хориглосон болон хязгаарласан химийн хорт болон аюултай бодисын жагсаалт”-д ороогүй химийн хорт болон аюултай бодис;

2.2.13.Арьс шир, ноос ноолуур угаах зориулалттай, бүх төрлийн савлагаатай гадаргуугийн идэвхт бодис, бэлдмэл;

2.2.14.Хүнсний бүтээгдэхүүний сав баглаа боодол үйлдвэрлэх зориулалттай анхдагч төлөвт байгаа полиэтилен, полиэтилентерефталат, полипропилен, поликарбонат;

2.2.15.Энэхүү журмын 2.2.1 дэх заалт нь химийн хорт болон аюултай бодисын тусгай зөвшөөрөл бүхий судалгаа, шинжилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээдэд хамаарах бөгөөд нэг жилд импортлох бодисуудын нийт хэмжээ нь 100 кг-аас ихгүй байна.

Гурав.Химийн хорт болон аюултай бодисыг экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, худалдах зөвшөөрөлтэй хүн, хуулийн этгээдэд тавигдах нэмэлт шаардлага

3.1.Химийн хорт болон аюултай бодисыг экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, худалдах зөвшөөрөл бүхий хүн, хуулийн этгээд дараах шаардлагыг биелүүлнэ. Үүнд:

3.1.1.Химийн бодисын тусгай зөвшөөрөл бүхий хүн, хуулийн этгээдийн импортолж, үйлдвэрлэсэн химийн бодис нь зориулалтын сав, баглаа боодол, стандартын шаардлага хангасан англи, орос, монгол хэл дээр үйлдэгдсэн хаяг, шошготой байна;

3.1.2.Химийн бодисын тусгай зөвшөөрөл бүхий хүн, хуулийн этгээд нь импортолсон болон үйлдвэрлэсэн бодисоо химийн бодисын тусгай зөвшөөрөлтэй хэрэглэгчдэд худалдана;

3.1.3.Химийн бодисын тусгай зөвшөөрөл бүхий хүн, хуулийн этгээд нь импортолсон болон үйлдвэрлэсэн бодисоо худалдахдаа тухайн бодисын хор, аюулгүй байдлын лавлах мэдээллийг заавал дагалдуулан өгнө;

3.1.4.Химийн бодисын тусгай зөвшөөрөл бүхий хүн, хуулийн этгээд нь тодорхой шалтгааны улмаас ашиглахгүй болсон илүүдэл бодисыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөлтэйгээр химийн бодисын тусгай зөвшөөрөлтэй хүн, хуулийн этгээдэд худалдаж болно.

3.2.Экспортлоход тавих нэмэлт шаардлага

3.2.1.Химийн бодис экспортлохдоо энэ журмын 3.1.5-д заасан шаардлагыг биелүүлэхээс гадна тухайн бодисыг олон улсын хэмжээнд болон хоёр талын хооронд худалдаалж болох эрх зүйн үндэслэл, хортой, аюултай бүтээгдэхүүнийг хил дамжуулан тээвэрлэх олон улсын конвенц, гэрээ, хэлэлцээрийн шаардлагыг хангасан тухай танилцуулга;

3.2.2.Химийн хорт болон аюултай бодис нийлүүлэгч, хүлээн авагч, тээвэрлэгч талуудын хооронд хийсэн гэрээ, хэлэлцээрийн эх хувь, түүний монгол хэл дээрх албан ёсны орчуулга болон бусад шаардлагатай бичиг баримт.

3.3.Импортлоход тавих нэмэлт шаардлага

3.3.1.Химийн бодис импортлохдоо энэ журмын 2.1, 3.1-т заасан шаардлагыг биелүүлэхээс гадна тухайн бодис бүтээгдэхүүний гарал үүслийн гэрчилгээ болон экспортлогч талын эрх бүхий байгууллагаас олгосон чанар, аюулгүй байдлын баталгаажсан гэрчилгээтэй байна;

3.3.2.Химийн хорт болон аюултай бодис импортлох зөвшөөрөлтэй хүн, хуулийн этгээд нь химийн хорт болон аюултай бодисыг хадгалах стандартын шаардлага хангасан агуулахдаа химийн хорт болон аюултай бодисын эрсдэлийн үнэлгээ бүхий “Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлан”-г хийлгэж, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар баталгаажуулсан байна;

3.3.3.Жилд 5000 тонноос дээш химийн бодис импортлох тусгай зөвшөөрөлтэй хүн, хуулийн этгээдийн агуулах нь суурьшлын бүсээс гадна байх бөгөөд эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хэмжээг холбогдох норм, стандартад заасан шаардлагын дагуу тогтооно;

3.3.4.Химийн хорт болон аюултай бодисын импортлох тусгай зөвшөөрөлгүйгээр Монгол Улсын хилийн боомтын хяналтын бүсэд нэвтрүүлэхийг хориглоно. Хэрэв нэвтрүүлсэн тохиолдолд импортлогч хуулийн этгээдийн зардлаар экспортлогч оронд буцааж, хуулийн хариуцлага хүлээлгэнэ.

3.4.Хил дамжуулан тээвэрлэхэд тавих нэмэлт шаардлага

3.4.1.Химийн бодисыг хил дамжуулан тээвэрлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд нь энэ журмын 3.5-д заасан шаардлагыг биелүүлэхээс гадна нийлүүлэгч улсын болон хүлээн авагч улсын холбогдох байгууллага, Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх асуудлыг хариуцсан этгээдийн хооронд байгуулсан гурвалсан гэрээ, эсхүл нийлүүлэгч тал дамжин өнгөрүүлэгч хооронд, хүлээн авагч болон дамжин өнгөрүүлэгч талуудын хооронд тус тусад нь хийсэн гэрээ хэлэлцээртэй байна;

3.4.2.Химийн бодисыг хил дамжуулан тээвэрлэхдээ Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэгт заасан боомтуудаар нэвтрүүлнэ;

3.4.3.Химийн бодисыг хил дамжуулан тээвэрлэхдээ төмөр замаар шууд тээвэрлэх шаардлагатай бөгөөд зайлшгүй ачиж буулгах шаардлага гарсан үед хилийн боомтоос бусад газар ачиж буулгахыг хориглоно;

3.4.4.Химийн бодисыг хил дамжуулан тээвэрлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд нь олон улсын гэрээ хэлэлцээр, конвенцын заалтуудад нийцүүлэн химийн бодисыг тээвэрлэнэ.

3.5.Үйлдвэрлэгчид тавих нэмэлт шаардлага

3.5.1.Химийн хорт болон аюултай бодис үйлдвэрлэх зөвшөөрөл бүхий хүн, хуулийн этгээд нь энэ журмын 2.1, 3.1-т зааснаас гадна дараах шаардлагыг биелүүлнэ;

3.5.2.Химийн хорт болон аюултай бодис үйлдвэрлэх зөвшөөрөл бүхий хүн, хуулийн этгээд нь химийн бодисыг хадгалах, ашиглах, худалдах үйл ажиллагаа явуулах стандартын шаардлага хангасан үйлдвэр, агуулахдаа байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар баталгаажсан Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланг хийлгэсэн байна;

3.5.3.Химийн хорт болон аюултай бодисыг үйлдвэрлэхдээ Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т заасан үндэсний зөвлөлийн шинжээчдийн багийн дүгнэлтийг гаргуулсан байна;

3.5.4.Химийн хорт болон аюултай бодисыг үйлдвэрлэгч нь үйлдвэрлэсэн бодисоо холбогдох стандартын шаардлага хангасан агуулахад хадгална;

3.5.5.Химийн хорт болон аюултай бодис үйлдвэрлэгч нь эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны шаардлага хангасан байранд, технологийн горимыг нарийн чанд баримтлан ажиллана;

3.5.6.Үйлдвэрлэгч нь орчиндоо болон ажлын байранд зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн бодис бүхий хорт хий, хог хаягдал гаргахгүй байх үүрэг хүлээх ба гаргасан тохиолдолд түүнийг бууруулах, саармагжуулах, байгаль орчинд халгүй аргаар устгах арга хэмжээг өөрийн хөрөнгөөр авч хэрэгжүүлнэ.

3.6.Худалдахад тавих нэмэлт шаардлага

3.6.1.Химийн хорт болон аюултай бодис худалдах зөвшөөрөлтэй хүн, хуулийн этгээд нь дараах шаардлагыг биелүүлнэ:

3.6.2.Химийн хорт болон аюултай бодис худалдах зөвшөөрөлтэй хүн, хуулийн этгээд нь химийн хорт болон аюултай бодисыг хадгалах, худалдах үйл ажиллагаа явуулах стандартын шаардлага хангасан агуулахын байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар баталгаажсан химийн хорт болон аюултай бодисын эрсдэлийн үнэлгээ бүхий “Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлан”-тай байна;

3.6.3.Химийн хорт болон аюултай бодисын тусгай зөвшөөрөлгүй хүн, хуулийн этгээдэд химийн хорт болон аюултай бодисыг худалдахыг хориглоно;

3.6.4.Химийн хорт болон аюултай бодисыг худалдахдаа худалдан авсан этгээдийн хаяг, бодисын нэр төрөл, хэмжээ, ашиглах зориулалтыг заасан баримтыг 2 хувь үйлдэн баталгаажуулж, нэг хувийг худалдан авагчид, үлдсэн хувийг өөртөө хадгална;

3.6.5.Химийн хорт болон аюултай бодисыг зориулалтын, тодорхой хаяг шошго бүхий савлагаатайгаар худалдана.